



БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2024 оны 08 сарын 02 өдөр

Дугаар А/588

Булган сум

Хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.2, 66 дугаар зүйлийн 66.1, Засгийн газрын 2024 оны “Худалдан авах ажиллагаанд баримтлах төсөвт өртгийн дээд хязгаар тогтоох тухай” 02 дугаар тогтоол, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны XIX хуралдааны “Булган аймгийн 2024 оны төсөв батлах тухай” XIX/08 дугаар тогтоол, аймгийн Засаг даргын “Шинэ хөгжлийн зам” үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай 2020 оны II/04 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.“Алтаргана 2024” олон улсын XV их наадмын ажлын хэсэг, орчуулагч нарын өдрийн хоолны зардалд шаардагдах 3,150,000 (гурван сая нэг зуун тавин мянга) төгрөг, “Алтаргана” наадмын олон улсын хорооны хурлыг зохион байгуулахад шаардлагатай туг захиалгаар хийлгэхэд 250,000 (хоёр зуун тавин мянга) төгрөгийг тус тус хавсралтаар баталсугай.

2.Дээрх зардлуудыг Булган аймаг, Уулын баяжуулах Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ын 2024 онд хамтран ажиллах төлөвлөгөөнд тусгагдсан “Байгаль орчныг хамгаалах зорилгоор байгальд ээлтэй аялал жуулчлалыг хөгжүүлэх чиглэлээр зохион байгуулах арга хэмжээ”-ний зардлаас санхүүжүүлэхийг Тамгын газрын дарга (Д.Алтаншагай) -д зөвшөөрсүгэй.




ЗАСАГ ДАРГА

Б.АРИУН-ЭРДЭНЭ

0324910775

02 дүгээр сарын 02-ны өдрийн 1/5.8 дугаар захирамжийн хавсралт



“Алтаргана 2024” XV наадын ажлын хэсэг, орчуулагч нарын өдрийн хоол болон Олон улсын хорооны хурлыг зохион байгуулахад шаардлагатай туг захиалгаар хийлгэх төсөв

№	Байрлах газар	Тоо ширхэг	Нэгжийн үнэ /төгрөгөөр/	Дүн /мян.төг/
1	Өдрийн хоол	30 хүн 3 өдөр	35,000	3,150,000
2	Туг	25	10,000	250,000
				3,400,000